

Энэхүү судалгааны ажлын зорилго нь олон наст вет, буурцагт ургамлын үр вйлдвэрлэлийн талбай дахь хог ургамалтай тэмцэх арга боловсруулахад оршино.

Манай орны ойт хээрийн бүсэд 2004 оноос эхлэн явуулсан олон наст вет, буурцагт ургамлын зүйл шалгаруулах судалгаагаар шалгарсан нутгийн эрлийз царгас (*Medicago varia*),

сибирь хялгана (*Stipa sibirica*)

), ОМОЗО-ы дагуур олонго (*Elymus dahuricus*)

), монгол ерхог (*Agropyron mongolicum*)

)-ийг ойт хээрийн бүсийн (Тов аймгийн Борнуур сум) усалгаатай ба усалгаагүй ноцолд тариалж хог ургамалтай тэмцэх дараах хувилбаруудыг туршлаа. Үүнд:

), монгол ерхог (*Agropyron mongolicum*)

)-ийг ойт хээрийн бүсийн (Тов аймгийн Борнуур сум) усалгаатай ба усалгаагүй ноцолд тариалж хог ургамалтай тэмцэх дараах хувилбаруудыг туршлаа. Үүнд:

), монгол ерхог (*Agropyron mongolicum*)

1. Хяналт (хог ургамалтай тэмцэхгүй)
2. Хог ургамлыг хадаж устгах
3. Хог ургамлыг гараар зулгааж устгах
4. Гербицид цацах
5. Таримал ургамлын мор хооронд сийрүүлэлт хийх

2007 онд хорсийг хаврын хагалгаагаар боловсруулсан талбайд, харин 2008 онд уриншилсан талбайд олон наст ургамлыг 6-р сарын эхээр мор хооронд 45 см зайтай тариалав.

Туршилтын хугацаанд таримал ургамлын хээрийн соёололт, амьдрах чадвар, хаврын сэргэн ургалт, оволжих чадвар, осолт, биомасс, хог ургамлын биомассыг тодорхойлов.

Судалгааны тоон материалд SPSS 16.0 програм ашиглан статистик боловсруулалт хийсэн.

Судалгаа явуулсан 2007, 2008 оны агаарын температур болон чийг (хур тундас) олон наст ургамлын ургахад тааламжтай байсан хэдий ч 2007 оны 5-р сард агаарын дундаж температур ОЖД-аас 4.4°C-аар доогуур байсан юм.

Усалгаатай ноцолд 2007 оны туршилтын талбайд вет ба буурцагт ургамлын хээрийн соёололт 36.9-69.6% байсан бөгөөд соёолсон ургамлын 50.8-83.0% нь намар хвртэл амьдарч тэдний 17.2-48.3% нь дараа жилийн хавар сэргэн ургалаа. Харин усалгаагүй ноцолд 2008 онд тарвсан ургамлын 17.0-54.0% нь соёолж соёолсон ургамлын 31.5-85.0% нь намар хвртэл амьдарч оволжилтод шилжсэн байна.

Олон наст ургамлын үр үржүүлгийн талбайн хог ургамлыг хадах, гараар зулгаах, гербицид цацах зэрэг аргаар 62.8-100% хвртэл багасгах боломжтой нь судалгаанаас харагдлаа. Гэтэл мор хоорондын боловсруулалтаар хог ургамлын ердөө 57.3-64.7%-ийг устгаж байгаа бөгөөд энэ нь таримлын мор хоорондох хог ургамлыг сайн устгах боловч таримлын морон дээрх хог ургамал усталгүй үлдэж ургалт нь идэвхждэгтэй холбоотой юм.

Жил бүрийн 7-р сард хог ургамлыг нь хадаж устгасан царгасны ногоон ба үрийн ургац арвин байгаа нь энэ таримал амьдралын 2 дахь жилээс эхлэн хог ургамлаа түрж ургах чадвартайг харуулж байна. Харин монгол ерхог хог ургамалд тэсвэр муутай нь ургац тааруу байгаагаар тайлбарлагдана.

{pdf}images/pdfbook/weed control.MGL.pdf{/pdf}